



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/78

Хэрлэн сум

Замын байрлал сонгох ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн ХШ.1.1.24-Д тусгагдсан "Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Хэнтий, Хэрлэн сум/"-ын ажлын 2019-2020 онд хэрэгжих 10,0 тэрбум төгрөгийн санхүүжилтэд тааруулан "Гео зураглал" ХХК-иас хүлээн авсан 15 төрлийн замын зураг төслийг Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Ц.Идэрбат

-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд  
Чингис хотын Захирагч

Нарийн бичгийн  
дарга:

Д.Баттулга

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц,  
төлөвлөлтийн бодлого хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд:

Э.Мөнх-Эрдэнэ

-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Г.Мөнхжаргал

-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын  
газрын Дэд бүтэц хариуцсан  
мэргэжилтэн

Д.Амгаланбаатар

-Аймгийн Засаг даргын зөвлөх

О.Од-Эрдэнэ

-Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ийн  
Хэнтий салбарын захирал

Х.Ганчулуун

-Цахилгаан түгээх сүлжээ салбарын  
захирал

Ч.Алтанзаяа

-"Харгуй" ТӨХК-ийн захирал

Б.Гантөмөр

-"Хэнтий Ус" ХХК-ийн Ерөнхий инженер

2. Улсын төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах болон Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулж өндөр ач холбогдолтой, шаардлага хангасан зураг төслийг сонгох ажлыг Хэрлэн сумын Засаг дарга /Ц.Идэрбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

